



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр  
сарын 25-ны өдөр

Дугаар 231


Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт  
оруулах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 19.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалт”-ын “3.Цагдаагийн гэрээт хамгаалалт (түр)-д байх объект” гэсэн хэсэгт “3. “Чингис хаан” олон улсын нисэх буудал (нийтийн эзэмшлийн бүсэд нийтийн хэв журам хамгаалах нэгж)” гэж нэмсүгэй.

2. “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг цагдаагийн байгууллагын гэрээт хамгаалалтад авсантай холбогдуулан 2016 онд шаардагдах зардлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд М.Зоригт, Сангийн сайд Б.Болор, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Нямдаваа нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хууль зүйн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Д.ДОРЛИГЖАВ